

**ХЭНТИЙ АЙМГИЙН ДАРХАН СУМЫН НУТАГТ ОРШИХ “ТӨМРИЙН ХҮДЭР
ХУУРАЙ СОРОНЗОН АРГААР БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭР”-ИЙН 2023 ОНЫ
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГЕСТРИЙН ДУГААР: 6073549

АГУУЛГА

1. ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	3
2.1.Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	5
2.2. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт	12
2.3.Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	15
2.4.Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	17
Тус төсөл нь баяжуулах үйлдвэр бөгөөд 2023 онд нөхөн сэргээлт хийхгүй болно.	17
2.5.Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөөний биелэлт	17
2.6.Нүүлгэн шилжүүлэх нөхөн олговор олгох арга хэмжээний биелэлт.....	17
2.7.Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	17
2.8.Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт.....	17
2.9.Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	26
2.10.Олон нийтэд тайлагнах хуваарь, төлөвлөгөөний биелэлт	27

1. ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Төслийн ерөнхий мэдээлэл

Төслийн нэр:

- Төмрийн хүдэр хуурай соронзон аргаар баяжуулах үйлдвэр

Төсөл хэрэгжүүлэх аж ахуйн нэгж, байгууллагын нэр:

- “Арвижих хүдэр” ХХК
 - Улсын бүртгэлийн дугаар:
 - Регистрийн дугаар: 6073549

Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг:

- Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 2-р хороо, Рокмон бюлдинг -800 тоот.
 - Утас: 976-99100759,
 - Мэйл хаяг: arvijikhuder@gmail.com

Төслийн хүчин чадал

- Тус баяжуулах үйлдвэр нь жилд 500000 тонн хүдэр боловсруулан баяжуулах бөгөөд жилд 300 хоног ажиллана.


Төслийн байршил:

“Арвижих хүдэр” ХХК ийн Баргилт Овоогийн төмрийн хүдрийн ордыг түшиглэн байгуулах хуурай соронзон аргаар баяжуулах үйлдвэр нь Хэнтий аймгийн Дархан сумын нутаг дэвсгэрт хамаарах ба Улаанбаатар хотоос 300 км т, Хэнтий аймгийн Дархан сумаас баруун урагш 35 км орчим, Бор Өндөр сумаас баруун хойш 20 км зайд байрлана.

- Талбайн байр зүйн зургийн нэрэлбэр: L-49–60
- Талбайн хэмжээ: 15 га

Хүснэгт 1.Төслийн талбайн булангийн цэгүүдийн солбицол

№	Уртраг			Өргөрөг		
	Градус	Минут	Секунд	Градус	Минут	Секунд
1	109	16	4.99	46	19	1.05
2	109	16	4.42	46	19	19.19
3	109	16	15.17	46	19	19.4
4	109	16	15.17	46	19	9.1
5	109	16	19.93	46	19	9.1
6	109	16	20.18	46	19	1.28



Зураг 1. Төслийн талбайн ерөнхий байршлын зураг

Үйлдвэрийн бүтэц:

- Түүхий эд буулган жигдрүүлэх талбай
- Хүдэр бутлан ангилан баяжуулах хэсэг
- Баяжмал хадгалах талбай
- Завсрын бүтээгдэхүүний талбай
- Хаягдлын овоолго
- Авто пүүний хэсэг
- Засвар үйлчилгээний хэсэг
- Цахилгаан хангамжийн хэсэг
- Ажилчдын байр
- Контор зэрэг хэсгүүдээс бүрдэнэ.


Үйлдвэрийн хүчин чадал: Баяжуулах үйлдвэрийн жилийн хүчин чадал 300 мян.тн хүдэр боловсруулж 142.4 мян.тн баяжмал гаргана. Үйлдвэрийн үндсэн тоног төхөөрөмжийн ашиглалт 80-90%-тай ажиллах үед баяжуулах үйлдвэрийн цагийн хүчин чадал 92.6 тн байна.

2.1.СӨРӨГ НӨЛӨӨЛЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хүснэгт 2.Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Хэрэгжүүлэхээр авсан арга хэмжээний биелэлт	
АГААРЫН БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ ТАЛААР			
Үйлдвэрийн үйл ажиллагаанаас үүсэх тоосжилт	Усалгааг тогтмол хийх	Хуурайшилт ихтэй өдрүүдэд болон тээврийн хэрэгслийн хөдөлгөөн ихэссэн үедүүдэд үйлдвэрийн хашаан доторх замын тоосжилтыг дарах усалгааг хийж ажилласан.	
	Тээврийн замыг сайжруулсан болгох	Өөрийн үйлдвэрийн хаягдал бүтээгдэхүүнээр шаардлагатай тохиолдол бүрд сайжруулсан замын хучилтыг тогтмол хийдэг .	
Утаа болон хийн бохирдол	Машин техникийг үзлэг оношлогоонд оруулах	Үйлдвэрийн үйл ажиллагаанд ковш-3, экскаватор-1, ачааны портер-1, ажилчдын жижиг оврын автобус-1, унагалдай-1, поо-1, нийтдээ 8 хүнд даацын машин механизм болон суудлын автомашиныг Агаарын бохирдлын тухай хуулийн дагуу оношилгоонд оруулж, татварыг бүрэн төлсөн.	
ГАЗАР ХӨРСӨН БҮРХЭВЧИНД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ			

Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Хэрэгжүүлэхээр авсан арга хэмжээний биелэлт	
Хөрсний бохирдлоос хамгаалах	Тээвэрлэлтийн замын 2 талаар тэмдэг, тэмдэглэгээ хийх	Ачилт тээвэрлэлт гээд бүхий л замын холбогдолтой тэмдэг тэмдэгдэгээг байршуулсан болно.	
	Хөрсний бохирдол үүсэхээс сэргийлэх болон олон салаа зам гаргахгүй байх	Нийт хөдөлгөөнт техник ашигладаг ажилчидад “Үйлдвэрийн бүсэд хөдөлгөөнт техник ашиглах журам”-ыг мөрдүүлж, технологийн замын маршрутыг зургаар гаргаж танилцуулах сургалтаар мэдээлэл олгодог.	
	Шатахуун түгээгүүрийн талбайг хатуу хучилттай болгох	Шатахуун түгээгүүрийн зам талбайг тэгшлэн, хайргаар болон цементээр хучилт хийж тэмдэгжүүлсэн	
ГАЗРЫН ДООРХ УСАНД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР			
Усны нөөц	Ус ашигласны төлбөр тооцоог цаг тухайд нь төлөх	Бор-Өндөр сумын Бор-Өндөр УБҮ болон “Бор-Өндөр хот тохижилт” ТБАГУТҮГ-тай 2023 оны “Хамтран ажиллах гэрээ”, “Хэрэглээнээс илүү гарсан усыг нийлүүлэх гэрээ дугаар ВИ-2022-04-01/”-г тус тус байгуулан цэвэршүүлж гаргасан саарал усыг буцааж үйлдвэрийн зориулалтайгаар ашиглах, хэрэглээнээс илүү гарсан усыг үйлдвэрт эргэлтийн усыг хангах зориулалтаар ашиглаж, үйл ажиллагааны явцад нийтдээ 205 сая төгрөгийг гэрээний дагуу тухай бүр нь төлж барагдуулж ажилласан.	

Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Хэрэгжүүлэхээр авсан арга хэмжээний биелэлт	
түвшин буурахаас сэргийлэх	Унд ахуйн усанд ус цэвэршүүлэх усны шүүлтүүр байршуулах	3н шатлалтай ус цэвэршүүлэгчийг байрлуулж холбосон	
	Ундны ус хадгалах савыг зориулалтын сав болгох	Ундны ус хадгалах болон зөөвөрлөх эрүүл ахуйн шаардлага хангасан ус хадгалах зориулалттай төмөр сав.	
БИОЛОГИЙН ТӨРӨЛ ЗҮЙЛИЙГ ХАМГААЛАХ ТАЛААР			
Ургамлан нөмрөг	Техникийн хөдөлгөөнд хяналт тавих	Баяжуулах үйлдвэр рүү явах замын дагуу 200м зайд хурдны хязгаарын тэмдэг-1, зүг чиг заасан тэмдэг-2, нийт 3ш тэмдэг байрлуулсан.	

Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Хэрэгжүүлэхээр авсан арга хэмжээний биелэлт	
	Тэрбум мод үндэний хөдөлгөөнд нэгдэж мод тарих. (Сумын БО-ны газартай хамтран тохиромжтой газар тарих)	Үйлдвэрийн бүсэд мод тарих боломжгүй тул Дархан сумын Цэцэрлэгт хүрээлэнд 210ш хайлаасны суулгац тарьсан.	 
Ан амьтдын шилжилт хөдөлгөөнд үзүүлэх нөлөөлөл	Тээвэрлэлтийн зам дагуу ан амьтны нүүдэл шилжилт, ороо орох газар зэргээр өнгөрөхдөө дуут дохио ашиглахгүй байх анхааруулга хийх	Замын хөдөлгөөнд оролцоход кемпийн ойролцоо дуут дохио хориглох тэмдэглэгээг ашигладаг	
	Хууль бус ан хийхгүй байх талаар ажилчидад сургалт явуулах	Хууль бус ан хийхгүй байх, байгаль орчинд ээлтэй байж амьтанд гэмтэл учруулахгүй байх, тоо толгойг хоргодуулахгүй байх болон “Зөрчлийн тухай хууль”-аар анхан шатны сургалтыг явуулсан	

Мод тарьсан байдал.

Дархан сумын Цэцэрлэгт хүрээлэнд 210ш хайлаасны суулгац тарьсан.



Модны нүх ухаж байгаа байдал




Мод суулгасны дараа усалгаа хийж байгаа



Хайлаас модны суулгац суулгаж байгаа

2.2. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хүснэгт 3. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт

Болзошгүй аюул, осол сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга	Хэрэгжүүлсэн арга хэмжээ
Байгалийн аюул гамшиг		
Байгалийн давтагдашгүй хүчин зүйл болох	Байгалийн аюул гамшгийн үед авах арга хэмжээний талаар сургалт зохион байгуулах	<p>Компанийн Гамшгаас хамгаалах төлөвлөгөө, Бор-Өндөр суман дахь Онцгой байдлын хэлтсийн даргаар, Гал унтраах шуурхай төлөвлөгөө, Галын аюулгүй байдлыг хангах дотоод журам”-ыг компанийн захирлаар баталгаажуулан ажилчдад танилцуулан гарын үсэг зуруулж, үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.</p> <p>Онцгой байдлын газраас сургалт орж байгаа зураг.</p> 
Галын аюул		
Төслийн үйл ажиллагаанд техникийн зориулалттай шатах, тослох материалын аюулгүй ажиллагааг хангаагүйгээс	Галын аюулаас урьдчилан сэргийлэх дүрэм, журам боловсруулж, түүнийг мөрдөн ажиллах	Захирлын 2020/03 тоот тушаалаар батлагдсан “Галын аюулгүй байдлыг хангах дотоод журам”-ыг нийт ажилчин албан хаагчид мөрдлөг болгон ажилладаг ба “Удиртгал сургалт”-аар мэдлэг мэдээлэл олгодог.
	Галын дохиоллын систем суурилуулах, гал унтраах хэрэгслийг зохих газруудад байрлуулах, байнгын бэлэн байлгах, аюулын гарцын байрлалыг заасан самбар, галын аюул гарах болзошгүй газруудад зурагт хуудас, тэмдэг тэмдэглэгээг байршуулах	Галын дохиоллын систем болон аюулгүй гарцын фосфортой тэмдэг тэмдэглэгээ, гал унтраах хэрэгслэлийг болон бүх цех хэсгүүдэд галын сарааны иж бүрдлийг бүрэн суурьлуулж ажилчидад танилцуулан сургалтаар тогтмол мэдээлэл өгдөг.

Болзошгүй аюул, осол сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга	Хэрэгжүүлсэн арга хэмжээ
галын аюул гарах	Ажиллагсдыг цахилгаан хэрэгсэлтэй харьцаж ажиллах арга ажиллагаанд сургаж, гал түймрийн үед хэрхэн ажиллах талаар сургалт зохион байгуулах	Шинэ ажилчид орох бүрд “Удиртгал сургалт”-аар цахилгааны аюулгүй ажиллагаа, галын аюулгүй ажиллагааг ордог. Жил бүр Онцгой байдлын газраар “Галын шуурхай төлөвлөгөө”, “Гамшгийн шуурхай төлөвлөгөө” зэргийг батлуулж нийт ажилчидад танилцуулдаг.
Аянга цахилгаан, хэт халалт, гэнэтийн хүчтэй цахилгаан гүйдлийн нөлөөгөөр галын аюул гарах	Шатахууны агуулахын бүрэн бүтэн байдалд хяналт тавьж, тодорхой ажилтанд хариуцуулна. Цахилгааны шитний аюулгүй байдал, газардуулгын акт, баталгаажуулалттай байх	ШТС-ын галын дүгнэлтийг сунгуулж батлуулсан. Шатахууны агуулахын бүрэн бүтэн байдлын үзлэгийг хариуцсан эзэн /нярав, пүүлэгч/ тогтмол хийж бүртгэл тэмдэглэл хөтөлдөг ба сар тутамд хийсэн үзлэгт /ХАБЭА-н инженер/ хяналт тавьж ажилладаг. Үйлдвэрийн бүсэд стандартын дагуу аянга зайлуулагчыг байрлуулсан.

2.2.1. Ажилчдын аюулгүй байдлыг хангах

Болзошгүй аюул ослын үед орон нутгийн эмнэлэг болон бусад байгууллагуудтай хамтран ажиллах талаар гэрээ байгуулж ажиллаж байна.

Ажиллагсдыг түймэр унтраах арга барилд сургах, гал гарсан тохиолдолд шуурхай унтраах арга хэмжээ авах сургалтанд хамруулж, гарын доорх материалаар хангасан.

Үйлдвэрийн ажилчдыг хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгч, эрүүл ахуй, аюулгүй ажиллагааг хангах сургалтанд хамруулж, семинар зохион байгуулсан.



Зураг 2. Яаралтай түргэн тусламжийн арга хэмжээ авах эмийн сан



Зураг 3. Ажлын байран дахь хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны зааварчилгаа, самбарууд


2.2.2. Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа болон галын аюултай тэмцэх талаар

Ашиглалтын тоног төхөөрөмж, техник, ажлын болон ахуйн байр савнууд, шатахуун түгээх цэг нь гал түймрээс хамгаалах хэрэглэлээр хангагдсан.

- ✚ Бүх ажилчид нормын хувцас, хамгаалах хэрэгслийг улиралд тохируулан хэрэглэдэг.
- ✚ Үйлдвэр дээр гарч болзошгүй гал түймрийг урьдчилан сэргийлж, уурхайн даргын тушаалаар галын бүлгэм байгуулж түүний ажиллах журмыг боловсруулан бүх ажилчдад танилцуулж хэвшлээ.
- ✚ Ашиглалтын тоног төхөөрөмж, техник, ажлын болон ахуйн байр, шатахуун түгээх цэг нь гал түймрээс хамгаалсан хэрэглэлээр хангагдсан.
- ✚ Бүх ажилчид нормын хувцас, хамгаалах хэрэгслийг улиралд тохируулан хэрэглэдэг ба хөдөлмөр хамгааллын зааварчилгааг өдөр бүр өгч хэвшсэн.
- ✚ Машин тоног төхөөрөмжийг тусгай газарт байрлуулсан.

2.2.3. Ажилчдад сургалт орж байгаа байдал



Ажлын байран дахь хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагаа, Галын аюулгүй байдлыг хангаж ажиллах болон Онцгой байдлын газраас сугалтыг тогтмол орж байгаа.





Сургалт орж байгаа байдал

2.3.ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 4. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Хэрэгжүүлсэн арга хэмжээ
АХУЙН ХОГ ХАЯГДАЛ		
<p>Ахуйн хэрэглээний хог хаягдал</p> <p>Буруу хадгалсан хог хаягдал түүний эх үүсвэрээс үнэрийн бохирдол гарах</p>	<p>Энгийн хатуу хог хаягдлыг ангилан ялгаж, эмх цэгцтэй хадгалах хогийн сав байршуулах.</p>	<p>Үйлдвэрээс болон ажилчын тосгоноос гарах хог хаягдлыг ахуйн болон аюултай гэж ангилан хаях хогийн цэг байгуулсан.</p> 
	<p>Үйлдвэрийн ажилчдад зориулан хог хаягдлын ангилан ялгаж хаях талаар заавар зөвлөмж бүхий зурагт хуудас, зөвлөмжүүдийг байршуулах</p>	<p>Хог хаягдлын ангилан ялгах заавар зөвлөмж тайлбар бүхий зурагт хуудас, зөвлөмжүүдийг объектод байрлуулсан</p> 

Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	
	Ажилчдыг хог хаягдлыг ангилан ялгаж хаях дадал суулгах	Хог хаягдлын ангилан ялгах заавар зөвлөмж тайлбар бүхий зурагт хуудас, зөвлөмжүүдийг объектод байрлуулснаар ажилчид хэвшиж байгаа	
ҮЙЛДВЭРИЙН ХОГ ХАЯГДАЛ			
Баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаанаас гарах хог хаягдал	Машин техникийн үйлчилгээ, засварын тусгай бэлтгэсэн талбайд явуулж хэвших.	Төмөр хуванцар болон шил лааз бусад хог хаягдлыг ангилан ялгаж хийдэг савтай бөгөөд орон нутагтай хог хаягдлын гэрээний дагуу ажилладаг	
	Ангилсан хог хаягдлаа дахин ашиглах, дахин боловсруулах тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжтэй гэрээний байгуулан нийлүүлж байх	“Бор өндөр хот тохижилт” ТБАГУУГ-тай дахивар хог хаягдал нийлүүлэх гэрээ байгуулан ажиллаж байна. /гэрээг хавсралтаар хавсаргав./	
АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ			
Аюултай хог хаягдал ил задгай хаях	Аюултай хог хаягдлыг ангилан ялгаж эмх цэгцтэй хадгалах цэг байгуулах	Үйлдвэрээс болон ажилчын тосгоноос гарах хог хаягдлыг ахуйн болон аюултай гэж ангилан хаях хогийн цэг байгуулсан.	

Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Хэрэгжүүлсэн арга хэмжээ
	Үйл ажиллагаанаас гарсан ажилласан тос тосолгоо, шатах тослох материалыг тусгайлан битүүмжлэл сайтай саванд хуримтлуулан хадгалах, дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлэх.	Ажилласан тос тосолгоо хуримтлуулах сав байршуулсан бөгөөд одоогийн байдлаар хаягдал тос тосолгоо үүсээгүй байгаа болно.

2.4. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Тус төсөл нь баяжуулах үйлдвэр бөгөөд 2023 онд нөхөн сэргээлт хийхгүй болно.

2.5. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

“Аривжих хүдэр” ХХК-ийн эзэмшиж буй газарт малчид болон орон нутгийн иргэдийн газар эзэмших эрхийн гэрчилгээтэй намаржаа, өвөлжөө, хаваржааны байршил байхгүй юм. Тиймээс нөхөн олговрын асуудал анхнаасаа байхгүй байлаа.

2.6. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

“Төмрийн хүдэр хуурай соронзон аргаар баяжуулах үйлдвэр”-ийн төслийн талбай нь нийт хэмжээгээрээ түүх соёлын өвийн үнэт зүйлс байхгүй болно.

2.7. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хүснэгт 5. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Хамгаалах арга хэмжээ	Хэрэгжүүлсэн арга хэмжээ
Тус сумын нутагт уурхайн эдэлбэр газар, орхигдсон талбайд тэгшлэн техникийн нөхөн сэргээлт хийх.	2023 онд дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ биологийн нөхөн сэргээлт 2.9 га-д хийсэн талбайн эргэлтийн цэг. Хэнтий аймгийн БОГ-аас өгсөн.
Биотехникийн арга хэмжээ авах	Дархан ууланд нутагшсан аргаль, буганд 2 тонн хужир татаж, хужир тавьдаг хуучин байршилүүдэд тараан тавьсан. /Тайланг хавсралтаар хавсаргав./

ХЭНТИЙ АЙМАГ ДАРХАН СУМЫН ДАРХАН УУЛАНД
ХИЙГДСЭН БИО ТЕХНИКИЙН АЖЛЫН ТАЙЛАН

2023.10.30

Арвижих Хүдэр ХХК-ы хөрөнгө оруулалтаар Дархан ууланд нутагтасан өргөл,
буганд 2 тонн хужир татаж, хужир тавьдаг хүүчин байршиллуудад тараан тавьлаа.



Био-техникийн ажлын тайланг Дархан сумын иргэн: *Х. Энхбаатар* Энхбаатар

Хянаж ажигсан Байгаль хамгаалагч: *Ц.Ганбат*



2.8. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт

Хүснэгт 6. Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлсэн биелэлт

Хяналт шинжилгээ хийх үзүүлэлт	Хяналтын цэгийн байршил	Хэрэгжүүлсэн арга хэмжээ
Агаарын чанар		
Тоос нийт (PM10, PM2.5)	Баяжуулах үйлдвэр дотор Үйлдвэрийн хашаан дотор Хүдэрийн овоолгын ойролцоо	Төслийн талбай орчмын агаарт агуулагдах PM2.5, PM10, нийт тоос (Нийт жинлэгдэгч бодис)-ны агууламжийг Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага MNS 4585:2016 стандарт аргачлалын дагуу DM106A маркийн зөөврийн багажийн тусламжтай тодорхойлсон.
Дуу шуугиан хэмжээ	Баяжуулах үйлдвэрийн ойр орчим	Үйлдвэрийн орчины дуу чимээг хэмжих багажаар хэмжихэд үйлдвэрийн дуу шуугиан ихтэй ажлын байрны орчинд 62.7дБ, үйлдвэрээс 2-оос доошүй км-т 59.0дБ хүртэл байна. Шуугианы хэмжилтийг Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага MNS 4585:2016 стандарт аргачлалын дагуу HAZ-SCANNER model HIM-6000 маркийн зөөврийн багажаар дуу шуугианы хэмжилт хийлээ.
Хөрс		
Хөрсний хүнд металлууд	Баяжуулах үйлдвэрийн хашаан дотор Хаягдлын далангийн ойролцоо Кемп ойролцоо	Төслийн талбайд мониторингийн цэгүүдээс хөрсний дээж авч, хөрсний агрохимийн, хүнд металлын дээжийг “Нарт ШУҮН Консалтинг” ХХК-ийн хөрс судлалын итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлсэн. /Шинжилгээний үр дүнг хавсаргалтаар хавсаргав./
Усны чанар		
Химийн найрлага	Худгийн ус (унд ахуйн ус) Ахуйн хаягдал ус	Гүний худгийн уснаас холбогдох аргачлалын дагуу дээж авч “Нарт ШУҮН Консалтинг” ХХК-ийн ус судлалын итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлсэн. /Шинжилгээний үр дүнг хавсаргалтаар хавсаргав./

1. Судалгааны талбайн агаарын чанар

Судалгааны байршил, хамрагдсан цэг

Хэнтий аймгийн Дархан сумын нутаг дэвсгэрт байрлах “Арвижих хүдэр” ХХК-ийн “Төмрийн хүдэр хуурай соронзон аргаар баяжуулах үйлдвэр”-ийн газар орчмын орчны агаарын бохирдлын дэвсгэр (фон) хэмжээг тодорхойлох нэг удаагийн хэмжилтийг хийв.

Тус үйлдвэрийн орчимд хяналт шинжилгээний цэгүүдийг сонгохдоо салхины зонхилох чиглэл болон нөлөөллийн түвшнийг чухалчилж үзсэн бөгөөд тухайн хээрийн судалгааны үед үйл ажиллагаа явагдаагүй байсан. Нийт хүдрийн овоолго, үйлдвэрийн хашаанд, баяжуулах үйлдвэр дотор гэсэн 3 цэгийг сонгон авч хэмжилт хийв.

Хэмжилт, үнэлгээний арга зүй: Үнэлгээний мэдээлэл цуглуулахад ажиглалтын болон хэмжилтийн аргуудыг ашиглан ажлын талбайн нийт тоос (Нийт жинлэгдэгч бодис) болон дуу шуугиан үзүүлэлтүүдийг тодорхойлов. Үүнд:


Нийт тоос (Нийт жинлэгдэгч бодис): Төслийн талбай орчмын агаарт агуулагдах $PM_{2.5}$, PM_{10} , нийт тоос (Нийт жинлэгдэгч бодис)-ны агууламжийг Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага MNS 4585:2016 стандарт аргачлалын дагуу DM106A маркийн зөөврийн багажийн тусламжтай тодорхойлсон.

Дуу чимээ: Шуугианы хэмжилтийг Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага MNS 4585:2016 стандарт аргачлалын дагуу HAZ-SCANNER model HIM-6000 маркийн зөөврийн багажаар дуу шуугианы хэмжилт хийлээ.

Дотоод орчны бичил цаг уурын үзүүлэлтэд: - Агаарын хэм, харьцангуй чийглэг, гэрэлтүүлэг, агаарын хөдөлгөөний DM106A зөөврийн багажийг ашиглан агшингийн хэмжилтийг

- Орчны агаарын температур, $^{\circ}C$
- Агаарын харьцангуй чийглэг, %
- Агаарын хөдөлгөөний хурд, км/цаг зэрэг үзүүлэлтийг хэмжин “Агаарын чанар-Техникийн ерөнхий шаардлага” MNS 4585:2016 стандартад харьцуулан үр дүнг тайлагналаа.

Хүснэгт 7.Хэмжилт хийсэн үзүүлэлт

№	Шинжилгээ	Бохирдуулагч үзүүлэлт	Хэмжилт хийх багаж, төхөөрөмж	Хэмжилт хийсэн багаж, төхөөрөмжийн зураг
1	Орчны агаарын шинжилгээ	Орчны агаарт тоосны хэмжээ $PM_{2.5}$ PM_{10} Нийт жинлэгдэгч бодис	DM106A	
2	Бичил цаг уур	Температур		
		Хурд Чийглэг		

Хяналт шинжилгээний үр дүн

Агаарын чанарыг гадна орчноос авсан нийт тоосны хэмжээг MNS 4585:2016 “Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага” стандарттай харьцуулахад хүлцэх агууламжаас даваагүй хэвийн хэмжээнд байна.

Хүснэгт 8. Төслийн талбайн агаар дахь тоосны хэмжилтийн үр дүн, мг/м³

№	Сорьц авсан цэг	Сорьц авсан өдөр	Сорьц авсан цаг	PM 1.0 тоосонцор	PM 2.5 тоосонцор	PM 10 тоосонцор
1	46°19'11.47"N 109°16'6.17"E	2023.11.20	12:42	0.02	0.04	0.05
2	46°19'11.96"N 109°16'6.02"E	2023.11.20	13:00	0.10	0.20	0.14
3	46°19'1.51"N 109°16'8.27"E	2023.11.20	14:05	0.07	0.04	0.09
Агаарын чанарын стандарт MNS 4585:2016				0.500	-	-

ДҮГНЭЛТ: Төслийн талбай, түүний орчмын агаарын чанарын үзүүлэлт нь Монгол улсын MNS 4585:2016 “Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага” стандарт хязгаараас хэтрээгүй байна.

2. Судалгааны талбайн газрын доорх усны чанар

Төслийн талбайд гүний худаг гаргасан бөгөөд энэхүү худгийн уснаас авсан дээжийг “Нарт ШУҮН Консалтинг” ХХК-ийн ус судлалын итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлсэн.

Хүснэгт 9. Усны шинжилгээний үзүүлэлтүүд

Анион	1 дм ³ -д байгаа			Катион	1 дм ³ -д байгаа		
	мг/л	мг-экв/л	мг/ экв/%		мг/л	мг-экв/л	мг/ экв/%
Cl⁻	51.00	1.44	21.53	Na⁺	13.00	0.57	8.47
SO₄²⁻	26.00	0.54	8.11	K⁺	2.00	0.05	0.77
NO₃⁻	4.00	0.06	0.97	Ca⁺	105.00	5.24	78.45
CO₃⁻	0.00	0.00	0.00	Mg⁺	10.00	0.82	12.32
HCO₃⁻	283.00	4.64	69.40	Fe	0.00	0.00	0.00
Дүн	364.00	6.68	100.00	Дүн	130.00	6.68	100.00
HCO ₃ -ийн хагасыг хассан анион катионуудын нийлбэр: 352.5 мг/дм ³ Анион катионуудын нийлбэр: 494 мг/дм ³ Ерөнхий хатуулаг: 6.06 мг-экв/дм ³ pH: 7.79 Хуурай үлдэгдэл, мг/л: 332 ppm Цахилгаан дамжуулах чадвар: EC-0.837 ds/m TDS:441 ppm					Физик чанар: Өнгө: 0-өнгөгүй Үнэр: 0-үнэргүй Булингар: тунгалаг		

Химийн бүрэлдэхүүнээрээ гидрокарбонатын анги, кальцийн бүлэг, II төрлийн цэнгэг буюу дунд зэргийн эрдэсжилттэй, бага хатуулагтай ус байна.



Зураг 4. Гүний худгийн ус

Хүснэгт 10. Цэвэршүүлсэн усны шинжилгээний үзүүлэлтүүд

Анион	1 дм ³ -д байгаа			Катион	1 дм ³ -д байгаа		
	мг/л	мг-экв/л	мг/ экв/%		мг/л	мг-экв/л	мг/ экв/%
Cl ⁻	51.00	1.44	22.25	Na ⁺	12.00	0.52	8.07
SO ₄ ²⁻	23.00	0.48	7.41	K ⁺	2.00	0.05	0.79
NO ₃ ⁻	1.50	0.02	0.37	Ca ⁺	100.00	4.99	77.15
CO ₃ ⁻	0.00	0.00	0.00	Mg ⁺	11.00	0.90	13.99
HCO ₃ ⁻	276.00	4.52	69.96	Fe	0.00	0.00	0.00
Дүн	351.50	6.47	100.00	Дүн	125.00	6.47	100.00
HCO ₃ -ийн хагасыг хассан анион катионуудын нийлбэр: 338.5 мг/дм ³ Анион катионуудын нийлбэр: 476.5 мг/дм ³ Ерөнхий хатуулаг: 5.89 мг-экв/дм ³ pH: 7.55 Хуурай үлдэгдэл, мг/л: 327 ppm Цахилгаан дамжуулах чадвар: EC-0.828 ds/m TDS:429 ppm						Физик чанар: Өнгө: 0-өнгөгүй Үнэр: 0-үнэргүй Булингар: тунгалаг	

Химийн бүрэлдэхүүнээрээ гидрокарбонатын анги, кальцийн бүлэг, II төрлийн цэнгэг буюу дунд зэргийн эрдэсжилттэй, бага хатуулагтай ус байна.

Хүснэгт 11. Химийн шинжилгээний үр дүнг Ундны ус, эрүүл ахуйн шаардлага, түүнд тавих хяналт MNS 0900:2018 стандарттай харьцуулсан байдал (Сорьц №1)

№	Химийн шинжилгээний үзүүлэлтүүд	Худгийн ус	Цэвэршүүлсэн ус	MNS 0900: 2018
1	Усан орчны (pH)	7.79	7.55	6.5-8.5
2	Cl ⁻ , хлорид	51.00	51.00	350.0
3	SO ₄ ²⁻ , сульфат	26.00	23.00	500.0
4	NO ₃ ⁻ , нитрат	4.00	1.50	50.0
5	Ca ⁺⁺ , кальци	105.00	100.00	100.0
6	Mg ⁺⁺ , магни	10.00	11.00	30.0

Шинжилгээний үр дүнг Ундны ус, эрүүл ахуйн шаардлага, түүнд тавих хяналт MNS 0900:2018 стандартын шаардлагатай харьцуулахад зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтрээгүй байна.

ДҮГНЭЛТ: “Нарт ШУҮН Консалтинг” ХХК-ийн ус судлалын итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлсэн шинжилгээний хариу нь химийн бүрэлдэхүүнээрээ гидрокарбонатын анги, кальцийн бүлэг, II төрлийн цэнгэг буюу дунд зэргийн эрдэсжилттэй, бага хатуулагтай ус байна. Шинжилгээний үр дүнг Ундны ус, эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ (MNS 0900:2018) харьцуулахад зөвшөөрөгдөх хэмжээнээс даваагүй байна.

3. Судалгааны талбайн хөрсний чанар

Хөрсний агрохимийн, хүнд металлын дээжийг “Нарт ШУҮН Консалтинг” ХХК-ийн хөрс судлалын итгэмжлэгдсэн лабораторид тус тус шинжлүүлсэн.

Хөрсний морфологи болон хими физик шинж чанар

Зүсэлт №1



Зураг 5. Зүсэлт №1-ийн газарзүйн байрлал, хөрсний зүсэлт хийсэн цэг

Хүснэгт 12. Судалгааны талбайн 1-р зүсэлт хийсэн цэгийн морфологи бичиглэл

Хөрсний морфологи бичиглэл		
Байршил	Хэнтий аймгийн Дархан сум	
Координат	46°19'1.51"N	
	109°16'8.27"E	
Өндөр	д.т.д 1416 метр	
Газрын гадаргын налуу	6.1 (градус)	
Ургамлын бүрхэвч	35-40%	
Хөрсний нэр	Уулын хүрэн хөрс	
Гүн	А. 0-10 10см	Цайвар хүрэн өнгөтэй, гадаргаасаа эхлээд сайр чулуутай, жошамлын үндэс багатай, элсэнцэр механик бүөөлдээхүүнтэй байна.

Хүснэгт 13. Төслийн талбайн зүсэлт хийсэн цэгийн химийн үзүүлэлт

№	Гүн, см	pH H ₂ O	ЦДЧ dS/m	Ялзмаг %	Давс	CaCO ₂	NO ₃ мг/100г	Солилцох суурь, мг-экв/100 гр		Шим тэжээлийн элементүүд мг/100 гр	
								Ca	Mg	P ₂ O ₅	K ₂ O
1	0-20	7.28	0.123	2.23	0.052	1.23	0.43	19	9	2.1	6

Химийн шинжилгээний үр дүнгээр хөрсний дээжийн ялзмагийн хэмжээ дунд зэрэг, ургамалд ашигтай хөдөлгөөнт фосфорын агууламж сайн ба калийн агууламж бага хангамжтай байна. Солилцох суурь (Ca+Mg мг-экв/100 гр) 28 мг буюу дунд, хөрсний урвалын орчин саармаг байна. Хөрсний хялбар уусах давсны агууламж (0.052) бага, 1.23%-ийн карбонаттай байна.

Хөрсний механик бүрэлдэхүүн

Хөрсний хатуу хэсгийг бүрдүүлж байгаа жижиг ширхгүүдийн хэмжээгээр нь ангилан тэдгээрийг хувиар илэрхийлснийг механик бүрэлдэхүүн гэнэ. Энгийн ширхгийн хэмжээгээр нь шороо ба чулуу гэсэн хоёр том бүлэгт хуваана. Хөрсний задлан шинжилгээнд бэлтгэхэд 1 мм-ийн шигшүүрээр шигших бөгөөд түүнээс том хэмжээтэйг чулуу, харин шигшигдэж орсон 1 мм-ээс бага ширхэгтэйг шороо гэнэ (Аваадорж бусад 2012).

Хүснэгт 14. Хөрсний механик бүрэлдэхүүн

№	Гүн, см	Механик бүрэлдэхүүн, % ширхгийн хэмжээ, мм						
		1-0.25	0.25-0.05	0.05-0.01	0.01-0.005	0.005-0.001	<0.001	<0.01
1	0-20	43.0	32.3	13.4	3.6	1.9	5.8	11.3

Хөрсний механик бүрэлдэхүүнийг тодорхойлох Н.А. Качинскийн ангиллын аргаар физик шаврын эзлэх хувиар тодорхойлоход элсэрхэг механик бүрэлдэхүүнтэй байна.

Хөрсний бохирдол

Хүнд металлын агууламж

Хөрсөн дэх зарим хүнд металлын агууламжийг тодорхойлох зорилгоор бид хүнд металлын 3 дээж авч “Нарт ШУҮН Консалтинг” ХХК-ийн хөрс судлалын итгэмжлэгдсэн лаборатори”-д тус бүр Ni, Cd, Pb, Zn, Cr, Cu гэсэн 6 элементийг задлан шинжлүүлсэн. Шинжилгээний үр дүнг дэлгэрэнгүй байдлаар доорх хүснэгтээр харууллаа.

Хүснэгт 15. Хөрсөн дэх зарим хүнд металлын агууламж

Дээж авсан цэгийн дугаар	Дээж авсан гүн, см	Хүнд металлын агууламж мг/кг					
		Ni /никель/	Cd /кадмий/	Pb /Хар тугалга/	Zn /цайр/	Cr /хром/	Cu /зэс/
Дээж 2	0-5	4.8	0.0	243.8	243.9	44.2	75.6
Зүсэлт 1	0-20	4.8	0.0	50.0	103.4	54.3	16.5
Дээж 3	0-5	0.0	0.0	37.5	226.1	29.3	64.0
Зөвшөөрөгдөх дээд хэмжээ /MNS 5850:2019/							
Элсэрхэг хөрс		60	1	50	100	60	60
Шавранцар хөрс		100	1.5	70	150	100	80
Шаварлаг хөрс		150	3	100	300	150	100

Хөрсөн дэх зарим хүнд металлын агууламжийг лабораторийн шинжилгээгээр тодорхойлж үр дүнг MNS 5850:2019 Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ стандарттай харьцуулахад элсэрхэг хөрсөнд агуулагдах зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс Хар тугалга (Pb) 193.8 мг-аар /Дээж 2/, Цайр 3.4 – 143.9 мг-аар, Зэс (Cu) 4 мг /Дээж3 / 15.6 мг-аар тус тус давсан байна.

Хөрсний эрүүл ахуй

Хүснэгт 16. Хөрсний эрүүл ахуйн шинжилгээний үзүүлэлтүүд

Дээжний дугаар	Нянгийн тоо MNS 6341:2012	Гэдэсний савханцрын титр (E.coli) MNS 5367:2004		Анаэробын (Cl.perfringens) MNS 6341:2012	
	Шинжилгээний хариу	Шинжилгээний хариу	Бохирдлын зэрэг	Шинжилгээний хариу	Бохирдлын зэрэг
Дээж 1	$6.0 \cdot 10^5$	0.01<	2	0.1<	1

Хөрсний эрүүл ахуйн шинжилгээний үр дүнг (MNS 3297:2019) Байгаль хамгаалал. Хөрс. Хот, суурин газрын хөрсний ариун цэврийн үнэлгээний үзүүлэлтийн норм, хэмжээ стандарттай харьцуулахад дээрх үзүүлэлт илрээгүй буюу хөрс бохирдолгүй байна.

ДҮГНЭЛТ: Тус талбайд уулын хүрэн хөрс тархсан. Тус хөрснөөс авсан химийн шинжилгээний үр дүнгээр хөрсний дээжийн ялзмагийн хэмжээ дунд зэрэг, ургамалд ашигтай хөдөлгөөнт фосфорын агууламж сайн ба калийн агууламж бага хангамжтай байна. Солилцох суурь (Ca+Mg мг-экв/100 гр) 28 мг буюу дунд, хөрсний урвалын орчин саармаг байна. Хөрсний хялбар уусах давсны агууламж (0.052) бага, 1.12%-ийн карбонаттай байна.

Хөрсөн дэх зарим хүнд металлын агууламжийг лабораторийн шинжилгээгээр тодорхойлж “Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ” (MNS 5850:2019)-ийн стандарттай харьцуулахад зөвшөөрөгдөх дээд хэмжээ болон хортой, аюултай агууламжаас бага байна.

Хөрсний эрүүл ахуйн шинжилгээний үр дүнг (MNS 3297:2019) Байгаль хамгаалал. Хөрс. Хот, суурин газрын хөрсний ариун цэврийн үнэлгээний үзүүлэлтийн норм, хэмжээ стандарттай харьцуулахад дээрх үзүүлэлт илрээгүй буюу хөрс бохирдолгүй байна.

2.9. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 17. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт

Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Хэрэгжүүлсэн арга хэмжээ
Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг эрх бүхий байгууллагаар гүйцэтгүүлэх (5 жилд 1 удаа).	Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа хийх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулсан хийлгэхээр тохиролцсон болно..
Орон нутгаас тавьсан санал хүсэлтийг харилцан тохиролцож шийдвэрлэж байх	Орон нутагтай хамтран ажиллах гэрээ байгуулсан.
Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам тогтоож мөрдөх	Байгаль орчны мэргэжилтэн авч ажиллуулж байгаа болно. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх талаар мэдээллийг уурхайн ажилчдад тогтмол сургалт зохион байгуулж ажиллаж байна.
